



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/415

Номгон

Аймгийн "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд зөвлөх чиг үүрэг бүхий аймгийн "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог ханган ажиллахыг Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн орлогч дарга (Н.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

642311070

Засаг даргын 2003 оны 08 дугаар сарын 03  
-ны өдрийн 41 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

**"ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Салбар зөвлөлийн орлогч дарга Эрүүл мэндийн газрын дарга
- Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Салбар зөвлөлийн гишүүд:
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
  - Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
  - Нэгдсэн эмнэлгийн дарга
  - Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
  - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
  - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
  - Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
  - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
  - Статистикийн хэлтсийн дарга
  - Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
  - Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
  - Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан ерөнхий мэргэжилтэн
  - Эх, барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан ерөнхий мэргэжилтэн
  - Засаг даргын тамгын газрын хэвлэлийн ажилтан
- Холбогдох төрийн бус байгууллага



**"ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН  
ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөлийн зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь 2021 оны Эрүүл мэндийн сайдын А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөө болон холбогдох бусад дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

**ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

2.1. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан дагаж мөрдөнө.

2.2. Салбар зөвлөл нь ажлаа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

2.3. Салбар зөвлөл нь харьяа байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангасан байна.

2.4. Орон тооны бус салбар зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга /асуудал хариуцсан мэргэжилтэн/, гишүүдээс бүрдэнэ.

2.5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шаардлагатай тохиолдол бүрд зарлан хуралдуулж, хуралдааныг зөвлөлийн дарга удирдан явуулна.

2.6. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын санаачилгаар эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхын санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

2.7. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.8. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн шийдвэрлэсэн асуудлаар тушаал, хурлын тэмдэглэл гарна. Хэлэлцсэн асуудлаарх холбогдох шийдвэрийг харьяа байгууллагуудад хүргүүлж хяналт тавьж ажиллана.

2.9.Салбар зөвлөл нь хуралдааны дэгийг энэ журамд нийцүүлэн өөрөө тогтооно.

2.10.Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

2.11.Салбар зөвлөлийн хуралдаанаас санал, зөвлөмж гарна.

2.12.Салбар зөвлөл нь хуралдаанаас гарсан санал, зөвлөмж, дүгнэлтийг холбогдох харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### ГУРАВ. ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЧИГ, ҮҮРЭГ

3.1.Аймаг, сумын түвшинд "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөөний бодлогын хэрэгжилтийг хангах

3.2.Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төр болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

3.3.Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах

3.4.Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээрх бодлогын баримт бичиг, тушаал, заавар, зөвлөмж, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах

3.5.Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж бусад төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдтэй уялдуулах

3.6. Аймгийн хэмжээнд эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үнэлгээ хийж, үр дүнг тооцон хэлэлцэж ажиллах

3.7."Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөө болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор хийгдэж буй төсөл, арга хэмжээнүүдэд хяналт тавьж дүн шинжилгээ хийх

3.8."Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний үйл ажиллагааны үр дүнгийн тайланг холбогдох албан тушаалтнаар албажуулан тогтоосон хугацаанд Эрүүл мэндийн яам, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд тус тус хүргүүлэх.

#### ДӨРӨВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

4.1.Зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байх бөгөөд аймгийн ИТХ-ын өмнө ажлаа хариуцаж дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлох

4.1.2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

4.1.3. Салбар зөвлөлийн хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.1.4. "Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тайлагнах, өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах

4.1.5 Салбар зөвлөлийн гишүүний ажил үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих асуудлыг зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх

4.2. Салбар зөвлөлийн орлогч дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1. Салбар зөвлөлийн даргын эзгүйд түүний даалгаснаар салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх

4.2.2. Салбар зөвлөлийн даргын эзгүйд зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

4.2.3. Салбар зөвлөлийн даргын эзгүйд хуралдааныг даргалан холбогдох асуудлыг хэлэлцүүлэх

4.3. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1. Салбар зөвлөлийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар Салбар зөвлөлийн даргад өдөр тутам тусалж ажиллах

4.3.2. Салбар зөвлөлийн гишүүдийг "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд"-ийн чиглэлээрх холбогдох мэдээ мэдээллээр хангах

4.3.3 Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, салбар зөвлөлийн даргаар батлуулах, гишүүдэд урьдчилан ажлын 5 өдрийн өмнө танилцуулах

4.3.4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд гишүүдээс санал авч, нэгтгэн боловсруулж батлуулах

4.3.5. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам тооцож, салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах

4.3.6. Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх

4.3.7. Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэл болон холбогдох тайлан, мэдээллээр архивын нэгж бүрдүүлэн хуульд заасан хугацаанд байгууллагын архивт хүлээлгэн өгөх

4.4. Салбар зөвлөлийн гишүүд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.4.1 Салбар зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд биечлэн оролцох

4.4.2.Салбар зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг чиг үүргийн дагуу хариуцан зохион байгуулах, тайлагнах

4.4.3.Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар санал гаргах, хуралдаанаар хэлэлцүүлэх.

#### ТАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн болон зохион байгуулалтын зардлыг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

5.2.Салбар зөвлөлийн гишүүд өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг өөрийн харьяалах байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_